



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/50/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2023 .02.17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа
Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuyad@gmail.com
Аудитор Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5.Аудитын илрүүлэлт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.14 № *2/33*

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- 2022 онд худалдан авсан шатахууны анхан шатны (шатахууны зөвшөөрлийн бичиг) баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын татварын цахим системд шивсэн борлуулалтын и-баримттай тулган шалгахад нийт 10,611.7 мянган төгрөгийн шатахууныг баримтгүйгээр орлого авч, зарцуулснаар тайлагнасан;

- "ЦЭСДА" ХХК-д зураг төсвийн үнэнд шилжүүлсэн 5,000.0 мянган төгрөгийн авлагыг бусад бараа үйлчилгээний зардлаар тайлагнасан;

- Дэлгэрэх Мөнхжаргал ХХК-д засварын материалын үнэд 1,866.4 мянга, Мөнхөд ундрах эрдэнэ ХХК-д бараа материалын үнэ гэж 2,550.0 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлого аваагүй бараа үйлчилгээний бусад зардалд хааж тайлагнасан;

005020199

D/2023-A4 Alban toot doc

- Бэлтгэн нийлүүлэгчийн байгууллага хоорондын тооцоогоор хүнс, бусад бараа материалын үнэд нийт 35,776.3 мянган төгрөгийг шилжүүлээд 1,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй;

- Тайлант хугацаанд 10,000.0 мянган төгрөгөөр байгууллагын хүндэт самбар хийлгэж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг гэснийг зөрчсөн;

- “Цэлмэг өглөө” ХХК-д материалын үнэ гэсэн нэхэмжлэхийн дагуу 7,109.5 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлого авахдаа 4,180.0 мянган төгрөгийг ажлын хөлс гэж орлого авч зарлагадсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” , Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг зөрчсөн,УСНББОУС12, УСНББОУС19 болон Оршин байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга , журам өөрчлөн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч Эрүүл мэндийн байгууллагууд нэг иргэнээр тооцсон нормативт зардлаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Үйл ажиллагааны орчинд бүтцийн өөрчлөлт гараагүй, дээрх тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон зардлыг ЭМД-ын сангаас өвчний оношийн төрлөөр, насны ангилалаар тогтоосон тарифт үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Дээрхи өөрчлөлттэй холбоотойгоор Эрүүл мэндийн байгууллагууд 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн, орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон зөрчил дутагдал нь төлөвлөлтийн шатанд бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн бөгөөд аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	328,865,835.36	174,822,068.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	103,240,366.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	103,240,366.16
3121	Төгрөг	00.00	103,240,366.16
31211	Төрийн сангийн харилцах	00.00	103,240,366.16
33	АВЛАГА	286,301,426.36	1,679,934.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	229,866.30	431,894.54
33300	Татаас, санхүүжилтийн авлага	284,420,500.00	00.00
335	Бусад авлага	1,651,060.06	1,248,040.06
3351	Байгууллагаас авах авлага	1,651,060.06	1,248,040.06
35	БАРАА МАТЕРИАЛ	42,564,409.00	69,901,768.00
351	Түүхий эд материал	3,224,284.00	10,116,820.00
35130	Эм боох материал	3,224,284.00	10,116,820.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	5,000,000.00
354	Хангамжийн материал	39,340,125.00	54,784,948.00
35410	Бичиг хэргийн материал	1,816,500.00	843,500.00
35420	Аж ахуйн материал	36,411,625.00	52,826,448.00
35460	Хүнсний материал	997,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	115,000.00	1,115,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	974,590,557.17	1,100,671,685.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	974,590,557.17	1,100,671,685.09
392	Биет хөрөнгө	931,132,557.17	1,057,213,685.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	860,578,923.01	860,578,923.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,962,686.19	-140,693,060.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,000,000.00	62,120,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,574,999.90	-9,826,666.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,599,129.85	365,913,379.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,420,444.48	-129,163,799.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,815,762.00	61,616,344.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,152,009.56	-20,393,444.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,062,200.00	9,832,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,813,317.56	-2,769,990.52
393	Биет бус хөрөнгө	43,458,000.00	43,458,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,458,000.00	43,458,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,303,456,392.53	1,275,493,753.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	580,027.90	2,930,020.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	580,027.90	2,930,020.50
413	Өглөг	580,027.90	2,930,020.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	229,147.00	511,179.60
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	328,381.00	2,396,341.00
4136	Бусад өглөг	22,499.90	22,499.90
41361	Байгууллагад төлөх өглөг	22,499.90	22,499.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,302,876,364.63	1,272,563,733.35
51	Засгийн газрын хувь оролцоо	1,302,876,364.63	1,272,563,733.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	247,732,382.97	247,732,382.97
51101	Өмч: - төрийн	247,732,382.97	247,732,382.97
512	Хуримтлагдсан үр дүн	403,806,621.71	373,493,990.43
51210	Өмнөх үеийн үр дүн	403,806,621.71	403,806,621.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-30,312,631.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	651,337,359.95	651,337,359.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,303,456,392.53	1,275,493,753.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,284,955,398.06	917,698,075.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,261,912.06	99,166,285.44
120	Нийтлэг татварын бус орлого	155,261,912.06	99,166,285.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	37,242,449.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	37,242,449.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үх	129,667,857.56	36,402,836.85
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бм	25,594,054.50	25,520,999.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,693,486.00	818,531,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	469,802,900.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	469,802,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	602,075,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,915,200.00	00.00
131107	Нэмэлт	516,160,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,083,970.00	32,246,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,083,970.00	32,246,900.00

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,731,416.00	786,284,890.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,731,416.00	786,284,890.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	874,181,411.56	927,885,499.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	874,181,411.56	927,885,499.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	831,845,938.21	910,547,351.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,091,276.65	396,504,277.54
210101	Үндсэн цалин	252,384,105.65	249,604,314.59
210102	Нэмэгдэл	70,690,863.00	111,251,637.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,763,778.00	5,205,996.94
210104	Урамшуулал	31,252,530.00	30,442,328.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,808,783.30	50,536,248.85
210201	Тэтгэврийн даатгал	38,893,346.98	35,953,990.49
210202	Тэтгэмжийн даатгал	3,775,371.33	3,689,344.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,983,335.96	2,911,155.41
210204	Ажилгүйдлийн даатгал	741,521.37	721,092.73
210205	Эрүүл мэндийн даатгал	7,415,207.66	7,260,665.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,330,370.00	31,938,368.33
210301	Гэрэл, цахилгаан	3,288,370.00	3,242,368.33
210302	Түлш, халаалт	28,642,000.00	28,696,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,032,047.00	76,878,735.00
210401	Бичиг хэрэг	1,563,500.00	15,109,220.00
210402	Тээвэр, шатахуун	26,818,520.00	38,674,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	805,800.00	767,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,029,152.00	3,381,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	335,000.00	18,945,900.00
210408	Бараа материал акталсны зардал	12,480,075.00	00.00
2105	Нормативт зардал	104,591,608.50	137,315,978.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,881,408.50	124,158,468.35
210502	Хоол, хүнс	7,748,200.00	13,157,510.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	962,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,061,999.90	2,544,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	960,000.00	330,000.00
210604	Урсгал засвар	1,101,999.90	2,214,000.00
2107	Томилолт, зочны зардал	322,000.00	1,276,000.00
210702	Дотоод албан томилолт	322,000.00	1,276,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	168,437,631.00	108,735,629.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,987,631.00	105,762,235.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	650,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	00.00	70,394.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,170,221.86	104,818,114.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,948,935.94	18,897,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,221,285.92	85,920,914.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,335,473.35	17,338,147.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,312,500.00	17,205,996.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,312,500.00	17,205,996.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	132,151.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	132,151.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,973.35	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,973.35	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	410,773,986.50	-10,187,424.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	35,100,000.00	20,125,207.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35,100,000.00	20,125,207.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-35,100,000.00	-20,125,207.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	375,673,986.50	-30,312,631.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	845,272,986.00	1,140,194,739.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	37,242,449.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	37,242,449.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	37,242,449.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	37,242,449.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	845,272,986.00	1,102,952,290.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	469,802,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	317,654,700.00	284,420,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,915,200.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,083,970.00	32,246,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,083,970.00	32,246,900.00

Гапуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,731,416.00	786,284,890.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,731,416.00	786,284,890.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	825,045,986.00	830,348,122.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	825,045,986.00	830,348,122.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	782,710,512.65	813,009,974.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,067,793.65	396,504,277.53
210101	Үндсэн цалин	220,557,828.55	256,724,141.36
210102	Нэмэгдэл	106,820,373.10	102,359,144.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,462,140.00	5,205,996.94
210104	Урамшуулал	29,227,452.00	32,214,994.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,833,463.00	49,917,344.50
210201	Тэтгэврийн даатгал	30,369,638.80	37,500,649.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,700,933.80	3,141,654.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,950,746.53	2,479,724.20
210204	Ажилгүйдлийн даатгал	737,685.27	613,234.75
210205	Эрүүл мэндийн даатгал	7,074,458.60	6,182,082.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,583,970.00	31,840,748.33
210301	Гэрэл, цахилгаан	3,488,370.00	3,144,748.33
210302	Түлш, халаалт	28,642,000.00	28,696,000.00
210303	Цэвэр, бохир ус	453,600.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27791480.00	72873740.00
210401	Бичиг хэрэг	1,147,000.00	14,244,920.00
210402	Тээвэр, шатахуун	22,594,480.00	40,733,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	974,100.00	767,800.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,825,900.00	1,580,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	15,547,500.00
2105	Нормативт зардал	46,931,206.00	108,629,670.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,929,806.00	86,814,570.50
210502	Хоол, хүнс	5,039,400.00	12,165,100.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	962,000.00	9,650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,209,200.00	3,827,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	960,000.00	610,000.00
210604	Урсгал засвар	1,249,200.00	3,217,000.00
2107	Томилолт, зочны зардал	322,000.00	1,276,000.00
210702	Дотоод албан томилолт	322,000.00	1,276,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	255,091,200.00	128,113,994.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	254,641,200.00	125,140,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	70,394.00

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,880,200.00	20,027,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,880,200.00	20,027,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,335,473.35	17,338,147.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,312,500.00	17,205,996.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,312,500.00	17,205,996.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	132,151.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	132,151.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,973.35	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,973.35	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,227,000.00	309,846,616.16
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,227,000.00	206,606,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,227,000.00	206,606,250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,227,000.00	206,606,250.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,227,000.00	206,606,250.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-20,227,000.00	-206,606,250.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	103,240,366.16
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	103,240,366.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	403,806,621.71	1,302,876,364.63

Галуул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	403,806,621.71	1,302,876,364.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	403,806,621.71	1,302,876,364.63
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-30,312,631.28	-30,312,631.28
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,337,359.95	373,493,990.43	1,272,563,733.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	908,293,800.00	735,195,724.87	173,098,075.13	80.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	908,293,800.00	735,195,724.87	173,098,075.13	80.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,293,800.00	735,195,724.87	173,098,075.13	80.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493,252,400.00	396,504,277.53	96,748,122.47	80.4
210101	Үндсэн цалин	342,995,800.00	256,724,141.36	86,271,658.64	74.8
210102	Нэмэгдэл	109,127,500.00	102,359,144.58	6,768,355.42	93.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,100,000.00	5,205,996.94	894,003.06	85.3
210104	Урамшуулал	35,029,100.00	32,214,994.65	2,814,105.35	92.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,656,600.00	49,917,344.50	11,739,255.50	81.0
210201	Тэтгэврийн даатгал	41,926,400.00	37,500,649.22	4,425,750.78	89.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,932,500.00	3,141,654.30	1,790,845.70	63.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,946,100.00	2,479,724.20	1,466,375.80	62.8
210204	Ажилгүйдлийн даатгал	986,500.00	613,234.75	373,265.25	62.2
210205	Эрүүл мэндийн даатгал	9,865,100.00	6,182,082.03	3,683,017.97	62.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,966,900.00	31,840,748.33	126,151.67	99.6
210301	Гэрэл, цахилгаан	3,150,900.00	3,144,748.33	6,151.67	99.8
210302	Түлш, халаалт	28,696,000.00	28,696,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	120,000.00	00.00	120,000.00	0.0

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	86,542,800.00	72,873,740.00	13,669,060.00	84.2
210401	Бичиг хэрэг	14,866,400.00	14,244,920.00	621,480.00	95.8
210402	Тээвэр, шатахуун	49,943,700.00	40,733,520.00	9,210,180.00	81.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	976,000.00	767,800.00	208,200.00	78.7
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00	300,000.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,756,700.00	1,580,000.00	3,176,700.00	33.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,700,000.00	15,547,500.00	152,500.00	99.0
2105	Нормативт зардал	121,805,100.00	108,629,670.51	13,175,429.49	89.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,661,200.00	86,814,570.50	5,846,629.50	93.7
210502	Хоол, хүнс	18,933,900.00	12,165,100.01	6,768,799.99	64.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,210,000.00	9,650,000.00	560,000.00	94.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,280,000.00	49,136,450.00	143,550.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,000,000.00	45,919,450.00	80,550.00	99.8
210604	Урсгал засвар	3,280,000.00	3,217,000.00	63,000.00	98.1
2107	Томилолт, зочны зардал	2,322,000.00	1,276,000.00	1,046,000.00	55.0
210702	Дотоод албан томилолт	2,322,000.00	1,276,000.00	1,046,000.00	55.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,153,600.00	3,070,394.00	2,083,206.00	59.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,000.00	97,000.00	603,000.00	13.9
210802	Аудит, баталгаажуулалт	1,300,000.00	650,000.00	650,000.00	50.0
210803	Даатгалын үйлчилгээ	233,600.00	70,394.00	163,206.00	30.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,400.00	00.00	38,400.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,400.00	00.00	10,400.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,871,200.00	2,253,000.00	618,200.00	78.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	563,144,000.00	219,471,100.00	34,367,300.00	39.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,314,400.00	21,947,100.00	34,367,300.00	39.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	908,293,800.00	838,436,091.03	69,857,708.97	92.3

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,246,900.00	32,114,748.03	132,151.97	99.6
132001	Орон нутгийн төсвөөс	32,246,900.00	32,114,748.03	132,151.97	99.6
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	876,046,900.00	806,321,343.00	69,725,557.00	92.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	876,046,900.00	806,321,343.00	69,725,557.00	92.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх” гэж зорилго зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад нийцүүлэн гарсан тогтоол, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин тайлант онд "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга , журам өөрчлөн батлах тухай " ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч , эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн журамд өөрчлөлт орж нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож эхэлсэн ба тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайлан ЭМЯ-нд нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,275,563.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 27,962.6 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	328,865.8	174,822.1	(154,043.8)
Мөнгөн хөрөнгө	-	103,240.4	103,240.4
Авлага	286,301.4	1,679.9	(284,621.5)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	42,564.4	69,901.8	27,337.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	974,590.6	1,100,671.7	126,081.1
Үндсэн хөрөнгө	1,218,964.0	1,403,968.6	185,004.6
Хуримтлагдсан элэгдэл	(244,373.5)	(303,297.0)	(58,923.5)
Нийт хөрөнгө	1,303,456.4	1,275,493.8	(27,962.6)
Өр төлбөр	580.0	2,930.0	2,350.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,302,876.4	1,272,563.7	(30,312.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,303,456.4	1,275,493.8	(27,962.6)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 103,240.4 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын санхүү даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны өөрчлөлт нь өмнөх оны ЭМД-ын сангаас авах авлагын үлдэгдэл 284,420.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,901.8 мянган төгрөг болж 27,337.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 281,986.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн ЭМГ-аар дамжуулан ЭМЯ бусад байгууллагаас 36,402.8 мянган төгрөгийн бараа, материалыг шилжүүлэн авч, 291,052.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,403,968.6 мянган төгрөг болж 185,004.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 206,606.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЭМГ-аас болон бусад эх үүсвэрээс 25,521.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, аймгийн ИТХ-ын 2022.09.16-ны өдрийн хуралдааны 10/46 дугаар тогтоолоор 17,422.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, 29,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий Фургон автомашиныг аймгийн ИТХ-д хөрөнгийг балансаас баланст шилжүүлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,272,563.7 мянган төгрөг болж 30,312.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд ЭМД-ийн сангаас санхүүжих нэг иргэнээр тооцсон зардлыг 698,367.4 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 154,990.4 мянган төгрөгөөр бууруулан 543,377.0 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой 8 удаа төсөвт өөрчлөлт оруулжээ

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 810,668.2 мянган , дээд шатны төсөв захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилан олгох буюу туслах үйл ажиллагааны орлогоос 65,378.7 мянган, орон нутгийн

төсвөөс санхүүжих тогтмол зардлын санхүүжилтэд 32,246.9 мянган , нийт зарлага санхүүжилтийг 908,293.8 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 740,942.6 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 65,378.7 мянган , орон нутгийн төсвөөс 32,246.9 мянган , нийт 838,568.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 735,195.7 мянган төгрөг буюу 80.9 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 132.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ЭМД-ийн сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан 69,725.6 мянган төгрөгөөр дутуу авсан, туслах үйл ажиллагааны орлогоос батлагдсан хэмжээнд санхүүжилтийг авч, олгосон санхүүжилтээс 103,240.4 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Эрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	908,293.8	735,195.7	173,098.1	88.6
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	32,246.9	32,114.7	132.2	100.0
АРГА ХЭМЖЭЭ 80302-Нэг иргэнд ногдох нормативт зардал	377,983.6	333,991.0	43,992.6	88.3
АРГА ХЭМЖЭЭ 81603- Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	432,684.6	314,929.4	117,755.2	72.8
АРГА ХЭМЖЭЭ 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан нэмэлт санхүүжилт	65,378.7	54,160.6	11,218.1	83.0

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 284,420.5 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны ЭМД-гийн сангаас авах авлагын гүйлгээ байна. Нэмэлт санхүүжилтийн дансыг 2022 оны 3-р сарын 31-нээр дуусгавар болгон хаах болсонтой холбоотой зарцуулагдаагүй үлдэгдлийн 18,029.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн дансанд хааж, батлагдсан төсвийг нэмэгдүүлж өгсөн байна .

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад 2022 оны 7-р сарын өөрчлөлтөөр батлагдсан төсөвт зардлын 544,300.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,164.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 6,123.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 908,293.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас дутуу санхүүжилтийн 69,725.6 мянган төгрөгийг хасч, 838,568.2 мянган төгрөгийн гүйцэтгэлээс 103,372.5 мянган төгрөгийг хэмнэсэн ба төрийн хэмнэлтийн хуулийн заалтад хамаарах дараах зардлыг хэмнэсэн байна. Үүнээс :

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 132.2 мянган төгрөг
- Хангамж, бараа материалын зардлаас 13,669.1 мянган төгрөг
- Нормативд зардлаас 13,175.4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тайлант онд тендер зарлаагүй ба дулаанаар хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, хүнсний материал худалдан авах 4 гэрээний 190,234.8 мянган, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,131,051.8 мянган төгрөгийн 19 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 341,172.7 мянган төгрөгийн 32 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 273,266.6 мянган төгрөгийн 15 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба аудитаар шатахууны худалдан авалттай холбоотой 7,182.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, жилийн эцсээр тодруулан шалгаж дүнг нэгтгэн танилцуулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулж байх 1 зөвлөмж өгсний хэрэгжилтийн тайланг 2022.11.01-ний өдрийн 125 дугаар бүхий албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Gas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0,00	1	0,00	100
Нийт дүн	1	0,00	1	0,00	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шатахууны зарцуулалт болон эмийн үлдэгдэл жил бүр нэмэгдэж байгаа тул төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нийлүүлэгдэж байгаа эмийн хугацаа, ашиглалт дээр анхаарч дүн шинжилгээ хийж төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах, төсвийн хөрөнгөөр авч буй үндсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа хууль тогтоомжид

нийцэж байгаа эсэх, түүний чанар, ашиглалтын байдалд Эрүүл мэндийн салбарын хэмжээгээр давтан аудит хийхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 13,596.4 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрч аудитын явцад залруулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022.04.22 нд Дэлгэрэх Мөнхжаргал ХХК-д засварын материалын үнэд 1866.4 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлогод аваагүй бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан.

2. Тайлант 2022.02.23 нд "Цэсда" ХХК-д зураг төсвийн үнэ гэж 5,000.0 мянган төгрөгийг шилжүүлж эрүүл мэндийн төвийн барилгын 2023 онд хийгдэхээр төлөвлөж буй их засварын ажлын зураг төсвийг хийлгэж бусад бараа үйлчилгээний зардлаар тайлагнасан

3. 2022.03.07-нд Цэлмэг өглөө ХХК-д материалын үнэ гэсэн нэхэмжлэхийн дагуу 7109.5 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлого авахдаа 4180.0 мянган төгрөгийг ажлын хөлс гэж орлого авч зарлагадсан ,

4. 2022 оны 3-р сард .Мөнхөд ундрах эрдэнэ ХХК-д бараа материалын үнэ гэж 2550.0 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлого аваагүй бараа үйлчилгээний бусад зардалд хааж тайлагнасан.

Аудитаар 21,931.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 11,931.6 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосноос 10,611.7 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 1 төлбөрийн актыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэж, зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх 10,000.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө. Үүнд:

5.1. Төлбөрийн акт

1. 2022 оны 7-р сард Ю.Оюунжаргалын ээлжийн амралттай байх хугацаанд ажил хавсарсны нэмэгдэл 319.9 мянган төгрөгийг бүтэн ажилласнаар тооцон илүү бодож олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин 319.9 мянган төгрөгийг Ю.Оюунжаргалаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Бэлтгэн нийлүүлэгчийн байгууллага хоорондын тооцоог анхан шатны баримттай тулган шалгахад ОСЭГ ХХК-д хүнс, бусад бараа материалын үнэд 1000.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3. "бүх өр төлбөр"-ийг заавал бүртгэнэ гэснийг зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Материалын үнэд илүү төлөөд бүртгээгүй 1,000.0 мянган төгрөгийн "ОСЭГ" ХХК-иар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. 2022 онд худалдан авсан шатахуун авах зөвшөөрлийн бичгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын e-tax-mta.mn цахим системд шивсэн борлуулалтын и-баримттай тулган шалгахад нийт 10,611.7 мянган төгрөгийн шатахууныг баримтгүйгээр орлого авч, зарцуулснаар тайлагнасан .

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй орлого авч зарцуулсан 10,611.7 мянган /арван сая зургаан зуун арван нэгэн мянга долоон зуун гучин нэгэн/ төгрөгийг Галуут сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, хуулийн байгууллагад шилжүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Тайлант хугацаанд худалдан авсан зарим нэр төрлийн эм, халаад, цагаан хэрэглэлийг үнийн дүнгээр нь орлого авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", гэснийг зөрчсөн.

Зөвлөмж: Тайлант онд үнийн дүнгээр орлого авсан бараа материалыг тоо ширхгээр нь задалж орлого авч тайланд зөрчлийг арилган цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Ажилтнуудыг ээлжийн амралттай байх хугацаанд ажлын зайлшгүй шаардлагаар ажиллуулах тохиолдолд ажилласан хугацааны цалинг илүү цагаар тооцон олгож , төсвийн хөрөнгөнд үрэлгэн хандсан

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна, 110 дугаар зүйлийн 110.2.Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно гэснийг тус тус зөрчсөн байна

Зөвлөмж: Цаашид зайлшгүй ажлын шаардлагаар ажилтныг ажиллуулах тохиолдолд цалин хөлсийг олгохдоо холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах

3. Тайлант хугацаанд 10000.0 мянган төгрөгөөр байгууллагын хүндэт самбар хийлгэж, төсвийн хөрөнгөнд үрэлгэн хандсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн үр ашиггүй зардал гаргах, төсвийн хөрөнгөнд үрэлгэн хандсан зөрчлийг арилгах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
1. Төсвийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022.04.22 нд Дэлгэрэх Мөнхжаргал ХХК-д засварын материалын үнэд 1866.4 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлогод аваагүй бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан	1	1,866.4			1	1,866.4	1	1,866.4				
2. Тайлант 2022.02.23 нд "Цэсда" ХХК-д зураг төсвийн үнэ гэж 5000.0 сая төгрөгийг шилжүүлж эрүүл мэндийн төвийн барилгын 2023 онд хийгдэхээр төлөвлөж буй их засварын ажлын зураг төсвийг хийлгэж бусад бараа үйлчилгээний зардлаар тайлагнасан	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0				
3. 2022.03.07-нд Цэлмэг өглөө ХХК-д материалын үнэ гэсэн нэхэмжлэхийн дагуу 7109.5 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлого авахдаа 4180.0 мянган төгрөгийг ажлын хөлс гэж орлого авч зарлагдсан ,	1	4,180.0			1	4,180.0	1	4,180.0				
4. 2022 оны 3-р сард Мөнхөд ундрах эрдэнэ ХХК-д бараа материалын үнэ гэж 2550.0 мянган төгрөгийг шилжүүлээд материалыг орлого аваагүй бараа үйлчилгээний бусад зардалд хааж тайлагнасан	1	2,550.0			1	2,550.0	1	2,550.0				
дүн	4	13,596.4			4	13,596.4	4	13,596.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1. 2022 оны 7-р сард Ю.Оюунжаргалын ээлжийн амралттай байх хугацаанд ажил хавсарсны нэмэгдэл 319.9 мянган төгрөгийг бүтэн ажилласнаар тооцон илүү бодож олгосон	1	319.9	1	319.9									
2. Бэлтгэн нийлүүлэгчийн байгууллага хоорондын тооцоог анхан шатны баримттай тулган шалгахад ОСЭГ ХХК-д хүнс, бусад бараа материалын үнэд 1000.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй	1	1,000.0	1	1,000.0									
3. 2022 онд худалдан авсан шатахуун авах зөвшөөрлийн бичгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын e-tax-mta.mn цахим системд шивсэн борлуулалтын и-баримттай тулган шалгахад нийт 10611731 төгрөгийн шатахууныг баримтгүйгээр орлого авч, зарцуулснаар тайлагнасан .	1	10,611.7	1	10,611.7									
4.Тайлант хугацаанд худалдан авсан зарим нэр төрлийн эм, халад, цагаан хэрэглэлийг үнийн дүнгээр нь орлого авсан	1	0,00						1	0,00				
5.Ажилтнуудыг ээлжийн амралттай байх хугацаанд ажлын зайлшгүй шаардлагаар ажиллуулах тохиолдолд ажилласан хугацааны цалинг илүү цагаар тооцон олгож , төсвийн хөрөнгөнд үрэлгэн хандсан	1	0,00						1	0,00				
6. Тайлант хугацаанд 10,000.0 мянган төгрөгөөр байгууллагын хүндэт самбар хийлгэж, төсвийн хөрөнгөнд үрэлгэн хандсан	1	10,000.0						1	10,000.0				
дүн	6	21,931.6	3	11,931.6				3	10,000.0				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

18/14425182

БНА-2023/50/НА-СТА-ТМБ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлтгэн нийлүүлэгчийн байгууллага хоорондын тооцоог анхан шатны баримттай тулган шалгахад "ОСЭГ" ХХК-д хүнс, бусад бараа материалын үнэд 1,000,000 төгрөгийг илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3. "бүх өр төлбөр"-ийг заавал бүртгэнэ гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Материалын үнэд илүү шилжүүлээд авлагаар бүртгээгүй 1,000,000 /Нэг сая/ төгрөгийг "ОСЭГ" ХХК-иар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нарт хариуцуулав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050054



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 19/14425182
БНА-2023/50/НА-ТӨС-СТА

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн 2022 онд худалдан авсан шатахууны зарцуулалтад аудит хийх явцад шатахуун авах зөвшөөрлийн бичиг, шатахуун зарцуулалтын жолоочийн тооцооны хуудас, "НИК" ХХК-иас худалдан авалт тухай бүрд POS системээс гаргаж өгсөн И-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын e-tax-mta.mn цахим системд шивсэн борлуулалтын и-баримттай тулган шалгахад нийт 10,611,731 төгрөгийн шатахууныг баримтгүйгээр орлого авч, зарцуулснаар тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 18.1.Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ гэснийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй орлого авч зарцуулсан 10,611,731 /арван сая зургаан зуун арван нэгэн мянга долоон зуун гучин нэгэн/ төгрөгийг Галуут сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар


005050057

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нарт хариуцуулав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

“ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР:  Д.ЦЭЦЭГМАА



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 201/4425182
БНА-2023/50/НА-СТА-Т042

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант 2022 оны 7-р сард ажилтан Ю.Оюунжаргалын ээлжийн амралттай байх хугацаанд ажил хавсарсны нэмэгдэл 319,922 төгрөгийг бүтэн ажилласнаар тооцон илүү бодож олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалин 319,922 /Гурван зуун арван есөн мянган есөн зуун хорин хоёр/ төгрөгийг ЭМТ-ийн дарга Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 1-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нарт хариуцуулав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА

6417143544
БН0А0067 9007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1/Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050058